

БАТЛАВ
 СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
 ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
 ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
 Д.ТӨМӨРБААТАР
 2026 оны 01 дугаар сарын 12 өдөр

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцан гүйцэтгэх ажилтны нэр
1	2	3	4	5	6
1	Монгол Улсын Их хурлын 2024 оны 27 дугаар тогтоол "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтөлж баталгаажуулах	Дотоод аудитын албаны Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажиллах	Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдана.	Жилдээ	Ёс зүйн хорооны дарга Ш.Болормаа
2		Дотоод аудитын албаны Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг мөрдөн ажиллах	Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдана.	Жилдээ	Ёс зүйн хорооны дарга, гишүүд
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, хариуцлагын бүртгэлийн хуудас нэвтрүүлж, хэрэглэж хэвшүүлэх	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангагдана.	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга М.Гүнчинсүрэн

4	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулах	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	2,4 дүгээр улиралд	Ёс зүйн хорооны дарга, гишүүд
5	Байгууллагын албан хаагчийн ёс зүйн зөрчлийн эрсдэлийг үнэлэх аргачлалын дагуу хэрэгжилтийг хангуулж үнэлэх	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	2 дугаар улиралд	Ёс зүйн хорооны дарга, гишүүд
6	Төрийн албаны ёс зүйн тайлбар, гарын авлага, зөвлөмж зааврыг төрийн албан хаагчид түгээх, сурталчлах, мэдээлэх ажлыг зохион байгуулах	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	2 дугаар улиралд	Ёс зүйн хорооны дарга, гишүүд
7	Төрийн албан хаагчийн ажлын цагийн бүртгэлд хяналт тавьж, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, шагнал, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэхэд санал өгөх	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	Улирал тутам	Ёс зүйн хорооны дарга, гишүүд
8	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	2,4 дүгээр улиралд	Ёс зүйн хорооны дарга, гишүүд

9		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдох тайлан, мэдээ, үйл ажиллагааны тайланг Ёс зүйн хороонд хүргүүлэх	Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдана.	Улирал бүр	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга М.Гүнчинсүрэн
---	--	--	---	------------	--

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



/ М.ГҮНЧИНСҮРЭН/

2026.01.12

(Огноо)

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ 2026 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга²

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын алба нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу нийт албан хаагчдын саналыг үндэслэн тус албаны даргын 2025 оны 10 сарын 10-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар Дотоод аудитын албаны ёс зүйн дэд хороог 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тус албаны Ёс зүйн дэд хорооны даргаар ахлах дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Ш.Болормаа, гишүүнээр нярав, архив бичиг хэргийн мэргэжилтэн С.Мөнхцэцэг, нарийн бичгийн даргаар дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч М.Гүнчинсүрэн нар ажиллаж байна.


ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт³:

1. Ёс зүйн дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хөтөлбөрийн шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн 9 заалт бүхий ажлыг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2. Дотоод аудитын албаны ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг боловсруулж албаны даргын 2026 оны А/13 дугаар тушаалаар баталгаажуулж ажилласан.

3. Мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийн үнэлгээг албаны нийт албан хаагчдаас авч үнэлж ажилласан болно.



3. Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс, Ёс зүйн академитай хамтран төрийн албан хаагчдад зориулсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн манлайлал" сургалтад 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр тус албаны ёс зүйн дэд хорооны дарга Ш.Болормаа хамрагдсан.

4. "Байгууллагын ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ыг Ёс зүйн дэд хорооны дарга ахлах дотоод аудитор Ш.Болормаа албаны албан хаагчдад 2026 оны 02 дугаар сарын 09-ний өөр танилцуулж сургалтыг зохион байгуулсан.



5.Тус албаны албан хаагчдад Бид авилга ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон аяны хүрээнд тус албаны дотоод аудитор М.Гүнчинсүрэн, Д.Гэрэлт-Од нар "Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" талаар сургалтыг 2026 оны 06 дугаар сарын 02-ний өдөр зохион байгуулсан. Нийт 5 албан хаагчид хамрагдсан.



6.Тус албаны Ёс зүйн хорооны гишүүн С.Мөнхцэцэг "Төрийн албан хаагчийн ёс зүйн" гарын авлагыг бэлтгэж, байгууллагын вэб сайтад байршуулж, төрийн албан хаагчдад нийт 50 ширхэг түгээж, сурталчилж ажилласан болно.






2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

- 2026 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол мэдээлэл бүртгэгдээгүй болно.
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг shd-audit.ub.gov.mn болон gov.mn цахим хуудсанд байршуулсан.
- Шударга, ил тод, хариуцлагатай төрийн албаны соёлыг төлөвшүүлэн, ёс зүйн хэм хэмжээг сахих хүрээнд тус албаны хөдөлмөрийн дотоод журмын 4.1, 6.2.3, 8.4.7, 8.4.8-дах заалтыг мөрдөж ажиллаж байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

- Монгол Улсын Ёс зүйн тухай хууль, ёс зүйн дэд хорооны ажиллах холбогдох журам, өлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг тус албаны албан ёсны вэб сайт болох shd-audit.ub.gov.mn байршуулж нийт 24 хүн үзэгчийн хандалт авсан байна. Мөн Төрийн байгууллагуудын нэгдсэн портал сайт болох gov.mn-д дээрх мэдээллийг байршуулж нэгдээлсэн.
- Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол мэдээлэл бүртгэгдээгүй.
- Албаны Сонгинохайрхан дүүргийн Дотоод аудитын алба фэйсбоок группд Ёс зүйн чиглэлээр постер бэлтгэж олон нийтэд суртчилах ажлыг зохион байгуулж ажиллалаа.



Гарсан үр дүн, ололт амжилт:

Бэрхшээл:

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээлэл бүртгэгдээгүй, хянан шалгах чиг үүргийн хүрээнд холбогдох этгээдэд шилжүүлсэн гомдол мэдээлэл байхгүй.	Байхгүй.
Санал:Үгүй.	

ТАЙЛАН БИЧСЭН.
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:



М.ГҮНЧИНСҮРЭН

ХЯНАСАН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА



Ш.БОЛОРМАА

2026 оны 06 сарын 09-ний өдөр